



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.4, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монголбанкнаас хэрэгжүүлж байгаа Орон сууцны ипотекийн зээлийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хянан шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий хяналт шалгалтын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Ж.Алдаржавхлан

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

Ажлын хэсгийн гишүүд:

Р.Сэддорж

-Монгол Улсын Их Хурлын гишүүн,
Эдийн засгийн байнгын хорооны дарга

Н.Батсүмбэрэл

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

Ш.Бямбасүрэн

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

Г.Лувсанжамц

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

М.Мандхай

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

П.Сайнзориг

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

А.Ундраа

-Монгол Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг Ажлын хэсэг (Ж.Алдаржавхлан)-т зөвшөөрсүгэй.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

